




ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2020 оны долоодугаар
сарын байдлаар






ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв

АТГАМҮӨД
ТҮГЭН



төсвийн орлогод эзлэх хувь 2020 оны 7 сарын байдлаар





ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Банк

МОНГОЛ БАНК МЭДЭЭ / сая төгрөг /



2019 VII

2020 VII

65 081.4

НИЙТ ХАДГАЛАМЖ

77 261.5

114 318.4

ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ

109 683.9

Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар буурч, 109 683.9 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 525.4 сая төгрөг, чанаргүй зээл 1 585.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 41.6 хувиар буурч, чанаргүй зээл 35.3 хувиар өссөн байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өсч, 77 261.5 сая төгрөг болсон ба мөн нийт харилцахын үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар буурч, 12 082.5 сая төгрөг болов

АТГАМГА
МОНГОЛ



Аж үйлдвэр
Түстэй



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – АЖ ҮЙЛДВЭР

АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ /САЯ.ТӨГ/



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2020 оны 7 сарын байдлаар 3 780.4 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 22.2 хувиар буурсан байна.



Амьдралын
статистик



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд



Эмнэлэгт эмчлэгдэж гарсан хүний тоо, амбулаторийн үзлэгийн тоо

	2018 I-VII	2019 I-VII	2020 I-VII
Эмчлэгдэн гарсан хүний тоо	6815	6631	6145
Амбулаторийн үзлэгийн тоо	99942	104044	107173

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 6132 эмчлүүлэгч хэвтэж, 6145 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 42678 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 6.9 байна. 2020 оны 7 сарын байдлаар 107173 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 28.3%, өвчний учир амбулаторийн үзлэг 49.7%, идэвхтэй хяналт 16%, гэрийн үзлэг 4.4%- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 33.6 хувь нь эрэгтэй, 66.4 хувь нь эмэгтэй хүн байна.



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

Амаржсан
эхийн тоо

Амьд төрсөн
хүүхдийн тоо

0-1
насны хүүхдийн
эндэгдэл

1-5
насны хүүхдийн
эндэгдэл

2018
I-VII

566

572

5

6

2019
I-VII

521

529

1

1

2020
I-VII

549

554

2


4

2020 оны 7-р сарын байдлаар 549 эх төрсөн ба нийт 554 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 28 төрөлтөөр өссөн байна. Төрсөн эхчүүдийн 91.1 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар 0-5 насны хүүхдийн 4 эндэгдэл гарсан байна.



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

Бүртгэгдсэн халдварт өвчлөлийн тоо



Халдварт өвчний 163 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 35.0 болж өмнөх оны мөн үеэс 100 тохиолдол буюу 21.4 пунктээр буурсан байна



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН, жил бүрийн 7 сарын байдлаар



	2018 VII	2019 VII	2020 VII
Ажил хайгч иргэн	575	526	478
Үүнээс эмэгтэй	301	241	226

2020 оны 7 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 478 хүн бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад 8.3 хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 47.3 хувь буюу 216 хүн нь эмэгтэйчүүд байна.




ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

АЖИЛГҮЙЧД
МАНД

Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд, 2020 оны 7 сарын байдлаар, сумаар



аймгийн хэмжээнд **148**



Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 148 ажил хайгч иргэн ногдож байхад Цагаандэлгэр 207, Говь-Угтаал 533, Өндөршил 341, Луус 210, Баянжаргалан 152, Гурвансайхан 269, Хулд 200, Дэлгэрхангай 234, Эрдэнэдалай 175 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

НИЙГМИЙН ХАЛАМЖИД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО 2020 оны 7 сарын байдлаар



2020 оны эхний 7 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 16773 хүнд 4003.3 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна.

Ажлын үндэсний статистик



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гэмт хэрэг

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧДЫН ТОО,
жил бүрийн 7 сарын байдлаар



БҮХ ХЭРЭГ



ХОЛБОГДОГЧ



Цагдаагийн хэлтсийн 2020 оны 7 сарын байдлаар Дундговь аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг 131 болж өмнөх оны мөн үеэс 1 хэргээр буюу 0.8 хувиар гэмт хэргийн гаралт буурсан байна. Гэмт хэрэгт нийт 82 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 холбогдогчоор буюу 30.1 хувь өссөн.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 303.8 сая төгрөг байна. 2020 оны 7 сард 10979 зөрчил шалгагдсан байна. Зөрчил гаргасан 10805 иргэнийг 335,5 мянган төгрөгөөр торгож тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасахаар 130 хүн, баривчлахаар 51 хүнд шийтгэл оноолоо.


АТГАМГАА
ТӨСӨН



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хэрэглээний үнэ

Дундговь аймгийн хэрэглээний үнийн индекс

(өмнөх оны 12 сар = 100)




- Тус аймагт 2020 оны 7 сарын байдлаар өмнөх оны 12 сартай харьцуулахад хэрэглээний үнийн индекс 3.8 хувиар өсжээ. Хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 12.8 хувиар, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 4.0 хувиар, хувцас бөс бараа гутал 3.5 хувь, орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад түлш 0.8 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 2.9 хувиар, эм тариа эмчилгээний бүлэг 3.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Албан ёсоор
түгш



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хэрэглээний үнэ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, /ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛСАНААР/



Тус аймагт 2020 оны 7 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэглээний үнийн индекс 7.1 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 14.5 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 4.3 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 9.6 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 6.8 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 6.1 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 3.5 хувиар өссөн, тээврийн бүлэг 4.1 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Албан ёсоор
Түгш



АТГАМГАД ТУУЛГА



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах тоглоом



Валютын ханш



1212.mn аппликейнаас
СТАТИСТИКИЙН
мэдээллээ аваарай



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС